



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2016 оны 12 сарын 26 өдөр

Дугаар А/348

Улаанбаатар хот

“Суралцагч шилжүүлэн суралцуулах журам”
шинэчлэн батлах тухай


Монгол Улсын Дээд боловсролын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалт, МУИС-ийн Захиргааны зөвлөлийн 2016 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ нь:

1.“Суралцагч шилжүүлэн суралцуулах журам”-ыг хавсралтаар баталж, 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.


2.Журмын хэрэгжилтийг зохион байгуулж, үр дүнд хяналт тавьж ажиллахыг Сургалтын нэгдсэн алба (Ч.Ундрам), Мэдээллийн технологийн алба (А.Баатарбилэг), бүрэлдэхүүн сургуулийн захирал, сургалтын албаны эрхлэгч нарт үүрэг болгосугай.

3.Энэ тушаал гарсантай холбогдуулан МУИС-ийн Захирлын 2015 оны А/375 дугаар тушаалаар батлагдсан “Суралцагч шилжүүлэн суралцуулах журам”-ыг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчингүй болгосонд тооцсугай.

ЗАХИРАЛ



Р.БАТ-ЭРДЭНЭ



Захирлын 2016 оны 12 дугаар сарын 26 -ний
өдрийн 1348 дугаар тушаалын хавсралт

СУРАЛЦАГЧ ШИЛЖҮҮЛЭН СУРАЛЦУУЛАХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Гадаад, дотоодын их, дээд сургуулиас Монгол Улсын Их Сургуульд (цаашид “МУИС” гэнэ), мөн МУИС-ийн бүрэлдэхүүн сургууль, салбар, хөтөлбөр хооронд оюутан, магистрант, докторант (цаашид бүртгүүлэгч гэнэ) шилжин суралцах асуудлыг зохицуулахад энэхүү журмыг (цаашид журам гэнэ) мөрдөнө.

1.2. МУИС-ийн бүрэлдэхүүн сургууль, салбар, хөтөлбөрт шилжин суралцах хүсэлт гаргасан суралцагчийг “бүртгүүлэгч”, шилжилтийн цахим бүртгэлийн системийг “бүртгэлийн систем”, шилжилтийн үйл ажиллагааг нэгдсэн байдлаар зохион байгуулахаар томилогдсон комиссыг “шилжилтийн комисс”, шилжилтийн үйл ажиллагааг зохион байгуулахад оролцох ажилтныг “комиссын гишүүн” гэнэ.

1.3. Шилжилт авах хөтөлбөр, хяналтын тоог салбар комиссын саналыг үндэслэн тухай бүрд нь зарлана. МУИС-ийн бүрэлдэхүүн сургуулийн мэргэжлийн хөтөлбөр сонгох хяналтын тооноос илүү гарахгүй байна.

1.4. МУИС-ийн салбар сургууль (Орхон, Завхан)-ийн хувьд хөдөө орон нутгийн онцлогийг харгалзан суралцагч шилжүүлэн суралцуулах өөрийн журамтай байхыг зөвшөөрнө. Журмыг МУИС-ийн сургалт эрхэлсэн дэд захирал баталгаажуулна.

Хоёр. Шилжилтийн комисс

2.1. Шилжилтийн үйл ажиллагааг төв болон салбар комисс хариуцан зохион байгуулна.


2.2. Төв комиссын даргаар сургалт эрхэлсэн дэд захирал, нарийн бичгийн даргаар сургалтын нэгдсэн албаны дарга, гишүүнээр бүрэлдэхүүн сургуулийн захирал, мэдээллийн технологийн албаны дарга, сургалтын нэгдсэн албаны сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн, элсэлт, төгсөлт, бүртгэл хариуцсан мэргэжилтэн, салбар комиссын даргаар бүрэлдэхүүн сургуулийн захирал, нарийн бичгийн даргаар сургалтын албаны эрхлэгч, гишүүнээр сургуулийн дэд захирал, тэнхим/нэгжийн эрхлэгч, бүрэлдэхүүн сургуулийн сургалтын албаны элсэлт, төгсөлт хариуцсан мэргэжилтэн, бүртгэл хариуцсан мэргэжилтэн ажиллана.

2.3. Төв комисс шилжилтийн ажлыг удирдамжаар хангаж, салбар комиссын үйл ажиллагаанд хяналт тавьж оролцоно.

2.4. Салбар комисс тухайн жилд шилжилт авах хөтөлбөрийн жагсаалт гаргах, хяналтын тоо тогтоох, шалгалтын хэлбэр, хуваарь гаргах, шалгалтын материал боловсруулах, шалгалт авах, дүгнэх, дүнг мэдэгдэх, системд оруулах, материал шалгах, багц цагийн дүйцүүлэлт хийх ажлыг хариуцна.

Гурав. Гадаадын их дээд сургуулиас шилжин суралцахад тавигдах шаардлага

3.1. Дэлхийн их, дээд сургуулийг эрэмбэлсэн жагсаалтанд МУИС-тай зэрэгцэн эсвэл дээгүүр эрэмбэтэй их дээд сургуулиас шилжин суралцах хүсэлт гаргасан бакалаврын түвшний бүртгүүлэгч сүүлийн 2 жилийн дотор 12-оос багагүй багц цагийн хичээл амжилттай судалж, нийт суралцсан хугацааны голч дүн 2.5-аас дээш байна.



3.2. Тус журмын 3.1-д заасан жагсаалтанд МУИС-аас доогуур эрэмбэтэй их дээд сургуулиас шилжин суралцах хүсэлт гаргасан бакалаврын түвшний бүртгүүлэгч сүүлийн 2 жилийн дотор 12-оос багагүй багц цагийн хичээл амжилттай судалж, нийт суралцсан хугацааны голч дүн 3.2-оос дээш байна.

3.3. МУИС-д шилжин суралцах хүсэлт гаргасан магистр, докторын түвшний бүртгүүлэгч гадаадын их, дээд сургуульд сүүлийн 2 жилийн дотор нэгээс доошгүй улирал 6-аас багагүй багц цагийн хичээл амжилттай судалж, нийт суралцсан хугацааны голч дүн 2.8-аас дээш байна.

Дөрөв. Дотоодын их, дээд сургуулиас шилжин суралцахад тавигдах шаардлага

4.1. МУИС-д шилжин суралцах хүсэлт гаргасан, төрийн өмчит их дээд сургуулийн бакалаврын түвшний бүртгүүлэгч хүсэлт гаргах улирлын өмнөх 2 жилийн хугацаанд хоёр улирал дараалан тус бүр 12-оос багагүй багц цагийн хичээл амжилттай судалж нийт суралцсан хугацааны голч дүн 3.0-аас багагүй байх ба дараах болзлын аль нэгийг хангасан байна. Үүнд:

4.1.1. Ерөнхий боловсролын сургуулийн төгсөх ангидаа БСШУЯ-аас баталсан улсын болон олон улсын олимпиад, эрдэм шинжилгээний хурал, спортын тэмцээнд оролцож байр эзэлсэн суралцагчдын хувьд шилжин суралцах сургуулийн элсэлтийн ерөнхий шалгалт (ЭЕШ)-ын аль нэгийг өгсөн байх.

4.1.2. Шилжин суралцах бүрэлдэхүүн сургуулийн ЭЕШ-ын зөрүүгүй байх ба оноо нь шилжих хүсэлт гаргаж байгаа жилийн элсэгчидийн онооноос өндөр байна.

4.2. Хувийн өмчийн их, дээд сургуулийн бакалаврын түвшний бүртгүүлэгч хүсэлт гаргах улирлын өмнөх 2 жилийн хугацаанд хоёр улирал дараалан тус бүр 12-оос багагүй багц цагийн хичээл амжилттай судалж нийт суралцсан хугацааны голч дүн 3.2-оос дээш байх ба тус журмын 4.1.1, 4.1.2 заалт дахь болзлын аль нэгийг хангасан байна.

4.3. МУИС-д шилжин суралцах хүсэлт гаргасан магистр, докторын түвшний бүртгүүлэгч дотоодын их, дээд сургуульд нэгээс доошгүй улирал 6-аас багагүй багц цагийн хичээл амжилттай судалж, нийт суралцсан хугацааны голч дүн 2.8-аас дээш байна.

Тав. МУИС-ийн хөтөлбөр хооронд шилжин суралцахад

тавигдах шаардлага

5.1. Дараах нөхцөлийг хангасан бакалаврын өдрийн хөтөлбөрийн бүртгүүлэгч өөр хөтөлбөрт шилжин суралцах хүсэлт гаргаж болно. Үүнд:

5.1.1. Хүсэлт гаргах улирлын өмнөх 2 жилийн хугацаанд дараалан хоёр улирал 12-оос багагүй багц цагийн хичээл амжилттай судалж, нийт суралцсан хугацааны голч дүн 2.8-аас дээш байх;


5.1.2. Суралцаж байгаа хөтөлбөртөө аль нэг байгууллагын гэрээт нөхцөлөөр элсээгүй байх;

5.2. Дараах нөхцөлийг хангасан бакалаврын орой, эчнээ хөтөлбөрт бүртгүүлэгч өөр хөтөлбөрт шилжин суралцах хүсэлт гаргаж болно. Үүнд:

5.2.1. Нэгээс доошгүй улирал 2.8-аас дээш голч дүнтэй суралцаж, улиралд 12-оос багагүй багц цаг цуглуулсан байх;

5.2.2. Суралцаж байгаа хөтөлбөртөө хөнгөлөлттэй нөхцөлөөр, эсвэл аль нэг байгууллагын гэрээний дагуу элсээгүй байх;

5.3. Магистр, докторын түвшний бүртгүүлэгч нь нэгээс доошгүй улирал 6-аас багагүй багц цаг цуглуулж, нийт суралцсан хугацааны голч дүн 2.6-аас дээш бол өөр хөтөлбөрт шилжин суралцах тухай хүсэлт гаргаж болно.



Зургаа. Шилжилтийн бүртгэл

6.1. Шилжилт авах хөтөлбөрийн жагсаалт, хяналтын тоо, шалгалтын хэлбэр, огноо, шалгалт авах өрөө, цаг зэрэг шилжилттэй холбоотой мэдээллийг шилжилт авах тухай бүрт нь салбар комиссын саналыг үндэслэн шилжилтийн төв комисс (хүснэгт 1) баталж бүртгэл эхлэхээс өмнө <http://num.edu.mn>, <http://shiljilt.num.edu.mn> цахим хуудсанд байршуулна.

6.2. Шилжилтийн бүртгэлийг хичээлийн жилд хоёр удаа: намрын улиралд 07 дугаар сарын 01-нээс 08 дугаар сарын 15-ныг дуустал, хаврын улиралд 01 дүгээр сарын 01-нээс 01 дүгээр сарын 15-ныг дуустал <http://shiljilt.num.edu.mn> хаягаар явуулна.

6.3. Бүртгүүлэгч нь бүртгэлийн системд өөрийн и-мэйл хаяг, нууц үгээ (МУИС-ийн хөтөлбөр хооронд шилжин суралцахыг хүсэгч нь оюутны дугаар, нэвтрэх үгээ) оруулан нэвтрэх зааврын дагуу хүсэлтээ гаргана.

6.4. Бүртгүүлэгч нь бүртгэлийн систем дэх анкетыг бөглөж, дараах бичиг баримтуудыг оруулна. Үүнд:

- Иргэний үнэмлэх эсвэл түүнтэй адилтгах баримт бичиг (МУИС-ийн хөтөлбөр хооронд шилжих хүсэлт гаргах бүртгүүлэгчид хамаарахгүй);
- Суралцаж байгаа сургуулийн суралцагч мөн болохыг баталсан тодорхойлолт (МУИС-ийн хөтөлбөр хооронд шилжих хүсэлт гаргах бүртгүүлэгчид хамаарахгүй);
- Дүнгийн тодорхойлолт* (тухайн сургуулийн сургалтын албаны тэмдэг, албан тушаалтны гарын үсэг, голч дүн, багц цаг бүхий албан бичиг бөгөөд МУИС-ийн хөтөлбөр хооронд шилжих хүсэлт гаргах бүртгүүлэгчид хамаарахгүй);
- Бакалаврын түвшний суралцагч бол бүрэн дунд; Магистрын түвшний суралцагч бол бакалаврын зэргийн; Докторын түвшний суралцагч бол магистрын боловсрол эзэмшсэнийг батлах баримт бичиг (МУИС-ийн хөтөлбөр хооронд шилжих хүсэлт гаргах бүртгүүлэгчид хамаарахгүй);
- Бакалаврын түвшний суралцагч тухайн сургуульд элсэхдээ өгсөн ЭЕШ-ын батламж бичиг (гадаадын их, дээд сургууль болон МУИС-ийн хөтөлбөр хооронд шилжих хүсэлт гаргах бүртгүүлэгчид хамаарахгүй);
- Цээж зураг (Зургийн шаардлагыг бүртгэлийн системээс үзэх бөгөөд МУИС-ийн хөтөлбөр хооронд шилжих хүсэлт гаргах бүртгүүлэгчид хамаарахгүй).
- Хүндэтгэх шалтгаантай бол нотлох бичиг баримт.

6.5. Тус журмын 6.4-д заасан бичиг баримт гадаад хэл дээр бол албан ёсны орчуулга хийлгэн, нотариатаар батлуулсан байна.

6.6. Бүртгүүлэгч нь хэдэн ч хөтөлбөрт шилжин суралцах хүсэлт гаргаж болох ба бүртгүүлсэн хөтөлбөрийн тоогоор бүртгэлийн хураамжийг цахимаар төлнө.


Долоо. Шилжилтийн шалгалт

7.1. Бүртгүүлэгч нь шилжихийг хүссэн хөтөлбөртөө бүрэлдэхүүн сургуулийн шаардлагын дагуу шалгалт өгнө.

* Гадаадын их, дээд сургуулиас бүртгүүлэгчийн дүнгийн тодорхойлолтонд тухайн оюутны цуглуулсан хичээлийн багц цаг, голч оноо, дүн нь заавал заасан байх шаардлагатай.

7.2. Шалгалтанд авбал зохих нийт онооны 60-аас доошгүй хувийг авсан шалгуулагчдыг оноогоор нь жагсааж, онооны дарааллаар хяналтын тоонд багтаан элсүүлнэ.

7.3. Оноо тэнцсэн тохиолдолд өмнө суралцсан хугацааны голч дүнг харгалзана.



Найм. Шилжин суралцах эрх олгох

8.1. Хяналтын тоонд багтсан эсэхийг шалгалт дууссаны дараа шалгуулагчид бүртгэлийн системээр мэдэгдэнэ.

8.2. Бүртгүүлэгч хэдэн ч сургууль, салбар, хөтөлбөрт бүртгүүлж, шалгуулж болох боловч зөвхөн нэг хөтөлбөрт шилжин суралцах эрх авна.

8.3. Хяналтын тоонд багтсан тухай мэдэгдэл авсан шалгуулагч бүртгэлийн системд оруулсан бичиг баримтыг эх хувиар нь (хяналтын тоонд багтсан бүх шалгуулагчид хамаарна) битүүмжлэл сайтай хавтсанд хийн заасан хугацаанд бүрэлдэхүүн сургуулийн сургалтын албанд бүртгүүлж, сургалтын мэдээллийн систем ашиглах эрх болон бүртгүүлэгчийн үнэмлэхээ авна.

8.4. Хяналтын тоонд багтсан шилжигч нь энэхүү журмын 8.3-д заасны дагуу бүртгүүлээгүй бол шилжин суралцах эрхээсээ татгалзсан гэж үзэж тус журмын 7.2 заалт дахь шаардлагыг биелүүлсэн дараагийн хүнд эрхийг шилжүүлнэ.

8.5. Сургалтын албаны мэргэжилтэн бүртгэлийн мэдээллийг эх бичиг баримтуудтай нь тулгаж баталгаажуулна.

Ес. Багц цаг дүйцүүлэх

9.1. Суралцагчийн өмнө үзсэн мэргэжлийн хичээлийн багц цаг дүйцүүлэлтийг бүрэлдэхүүн сургуулийн мэргэжлийн тэнхим, ерөнхий суурь хичээлийн багц цаг дүйцүүлэлтийг бүрэлдэхүүн сургуулийн сургалтын алба хийж шилжүүлэн суралцуулахыг МУИС-ийн захирлын тушаалаар баталгаажуулна (хүснэгт 2).

9.2. Бакалаврын түвшний оюутны өмнө судалсан хичээлүүдийн багц цагаас 45-аас хэтрэхгүй багц цагийг шилжүүлэн тооцож болно. МУИС-ийн хөтөлбөр хооронд шилжих тохиолдолд хөтөлбөрүүдийн ижил төстэй байдлаас хамааран дүйцүүлэх багц цаг нь 75 хүртэл байна.


9.3. Магистрын түвшний суралцагчийн өмнө судласан хичээлүүдийн багц цагаас гадаадын нэр хүндтэй их, дээд сургууль бол 9-өөс, дотоодын их, дээд сургууль бол 6-аас, МУИС-ийн хөтөлбөр хооронд бол 12-оос хэтрэхгүй багц цагийг тус тус дүйцүүлэн тооцож болно.

9.4. Докторын түвшний суралцагчийн өмнө судалсан хичээлүүдийн багц цагаас гадаадын нэр хүндтэй их сургууль бол 15-аас, дотоодын их, дээд сургууль бол 9-өөс, МУИС-ийн хөтөлбөр хооронд бол 18-аас хэтрэхгүй багц цагийг тус тус дүйцүүлэн тооцож болно.

9.5. Суралцагчийн үзэж судалсан тухайн хичээлийн багц цаг нь МУИС-ийн харгалзах хичээлийн багц цагт хүрэхгүй бол шилжүүлэн тооцохгүй. Багц цагийн дутууг харгалзах цагийн хэмжээгээр нэмж судлах мэтээр нөхөн гүйцээх боломжгүй. Илүү байгаа тохиолдолд МУИС-д баримталж байгаа тухайн хичээлийн багц цагаар шилжүүлнэ.

9.6. Хэрэв тухайн сургуулийн багц цагийн тодорхойлолт МУИС-ийнхаас өөр буюу сургалтын агуулгыг цагаар тооцдог бол МУИС-ийн Сургалтын журмын 1.10.27, 1.10.28-д зааснаар шилжүүлэн тооцно.

9.7. Судалсан багц цаг, голч дүнг тодорхойлох боломжгүй тохиолдолд салбар комисс хэлэлцэж, тухайн бүртгүүлэгчийг шилжүүлэх эсэх шийдвэрийг протоколоор төв комисст



хүргүүлнэ (хэрэв уг сургуулийн үнэлгээний тогтолцоо онооноос өөр бол оноонд хэрхэн харгалзуулах тухай албан ёсны тайлбар эсвэл цахим хуудасны бичвэр шаардах бөгөөд хэрэв боломжгүй бол амжилттай дүнг 60-95 онооны завсарт жигд харгалзуулах замаар шилжүүлэн тооцож болно. Тухайлбал, тухайн сургуульд оюутны мэдлэгийг онц, сайн, дунд, муу гэж үнэлдэг бол 60-71, 72-83, 84-95 оноог амжилттай дүнд харгалзуулан дунд - 66, сайн -78, онц -90 гэж оноох юм уу, эсвэл үнэлгээг тооцсон багц цагийн нарийвчлалтай холбож багц цагийг бууруулан тооцсон бол интервалын дээд оноог харгалзуулж болно).

9.8. Дүйцүүлсэн хичээлийг сургалтын мэдээллийн системд тухайн хичээлийн жилийн шилжиж ирсэн улиралд оноож, МУИС-ийн хөтөлбөр хооронд шилжиж байгаа бол үндсэн үнэлгээгээр бусад гадаад, дотоодын их, дээд сургуулиас шилжин ирж байгаа бол CR үнэлгээгээр оруулна.

Арав. Шилжилттэй холбоотой зардал

10.1. Бүртгэлийн хураамж нь шилжин суралцах хүсэлт гаргасан бүрэлдэхүүн сургуулийн тухайн хөтөлбөрийн 1-р түвшний 1 багц цагийн төлбөртэй тэнцүү байна.

10.2. МУИС-ийн бүрэлдэхүүн сургууль, салбар, хөтөлбөр хооронд шилжин суралцах болзол хангаж шилжих эрхээ авсан суралцагч шилжилтийн зардал төлөхгүй.

10.3. Гадаад, дотоодын их, дээд сургуулиас МУИС-д шилжин суралцах болзол хангаж шилжих эрхээ авсан бүртгүүлэгч шилжилтийн зардлыг шилжин суралцах хөтөлбөр харьяалагдах бүрэлдэхүүн сургуулийн дансанд төлнө.

10.4. Шилжилтийн зардал нь шилжин суралцах эрхээ авсан жилийн суурь үйлчилгээний төлбөртэй тэнцүү байна.

10.5. Бүртгэлийн хураамжийн 70 хувийг бүрэлдэхүүн сургууль бүртгэл шалгалт зохион байгуулахад, 30 хувийг МУИС-ийн төвлөрсөн санд төвлөрүүлнэ.

10.6. Бүртгэлийн хураамж болон шилжилтийн зардлыг буцаан олгохгүй.

Арван нэг. Бусад

11.1 Тухайн хөтөлбөртөө сургалтын хэлбэрээ (орой, эчнээ, судалгааны, мэргэжлийн) өөрчлөх бол тухайн бүрэлдэхүүн сургуулийн захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэж захирлын тушаалаар баталгаажуулна.

11.2 Шилжихтэй холбоотой бичиг баримтыг хуурамчаар үйлдсэн нь тогтоогдвол МУИС-д шилжүүлэхгүй, шилжсэний дараа энэ зөрчил илэрвэл сургуулиас хасна.

11.3 Тодорхой хүндэтгэх шалтгаанаар /эрүүл мэнд, ар гэрийн гачигдал болон улс төр, байгалийн давагдашгүй хүчин зүйл зэрэг/ бүртгүүлэгчид тус журмын 3.1, 3.2, 3.3 дахь заалтууд үйлчлэхгүй.

11.4 Тус журмын 11.4 дахь заалтаар бүртгүүлэгч тухайн жилд хүчинтэй эмнэлэг/эмчийн тодорхойлолт, өвчний түүх зэрэг нотлох бичиг баримтыг бүртгүүлэхдээ шилжилтийн системд хавсаргаж бүртгүүлээгүй бол 5.1 дэх заалтыг мөрдөнө.

*** *** ***

Хүснэгт 1

Суралцагч шилжүүлэн суралцуулах хөтөлбөрийн жагсаалт



Бүрэлдэхүүн сургууль	Хөтөлбөрийн нэр, индекс,	Хяналтын тоо	Шалгалтын хэлбэр	Шалгалт авах байр, өрөө	Шалгалт авах огноо, цаг
Шинжлэх ухааны сургууль					
Бизнесийн сургууль					
Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургууль					
Хууль зүйн сургууль					
Хэрэглээний шинжлэх ухаан инженерчлэлийн сургууль					
Орхон сургууль					
Завхан сургууль					



**Багц цагийг дүйцүүлэн
тооцох хүснэгт**

Оюутны овог нэр:

Оюутны дугаар: (ID)

Шилжин суралцах хөтөлбөр:

түвшин

Өмнө нь суралцаж байсан хөтөлбөр

Оюутнаар шилжин суралцуулсан тушаалын дугаар:

Огноо: 201.... оны сарынөдөр

№	Өмнө сургуульд үзсэн хичээл	Багц цаг	Дүн	Дүйцүүлэн тооцох хичээл	Багц цаг	Дүн
1.						
2.						
3.						
4.						
5.						
6.						
7.						

Дүнг дүйцүүлсэн:

Зөвшөөрсөн оюутан:

Баталгаажуулсан: /Тэнхимийн эрхлэгч/

Дүн оруулсан: /СА-ны мэргэжилтэн/

Хянасан /гарын үсэг, тамга/: /СА-ны эрхлэгч/